



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/41

Алтай хот

┌ Жагсаалт шинэчлэн батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 4.3.1, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт, тэдгээрийн нууцтай танилцах эрхийн түвшинг хавсралтаар баталсугай.

2.Жагсаалтад орсон албан тушаалтан солигдсон тухай бүр холбогдох хууль, журамд заасны дагуу аюулгүй байдлын шалгалтад хамруулан баталгаа гаргуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нууц хамгаалах ажилтан (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2013 оны
01... дугаар сарын 22-ны өдрийн
А/4/ дугаар захирамжийн хавсралт



**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦТАЙ ТАНИЛЦАХ ЭРХ БҮХИЙ
АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ, ТЭДГЭЭРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ
ЭРХИЙН ТҮВШИН**

№	Эрх бүхий албан тушаал	Танилцах эрхийн түвшин, зэрэглэл		
		1 дүгээр түвшин буюу "онц чухал нууц", "маш нууц", "нууц" зэрэглэл	2 дугаар түвшин буюу "маш нууц", "нууц" зэрэглэл	3 дугаар түвшин буюу "нууц" зэрэглэл
1	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга		+	
2	Аймгийн Засаг дарга	+		
3	Аймгийн Засаг даргын орлогч		+	
4	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга	+		
5	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга		+	
6	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга		+	
7	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга		+	
8	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга		+	
9	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга		+	
10	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга		+	
11	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга	+		
12	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер	+		
13	Аймгийн Засаг даргын Тамгын газрын нууц хамгаалах ажилтан	+		
14	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээлэл технологи, сүлжээ хариуцсан мэргэжилтэн			+
15	Сумдын Засаг дарга		+	
16	Сумын Засаг даргын Тамгын газрын дарга		+	